ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 21 өдөр Дугаар А/106 Арвайхээр сум

Газар эзэмшүүлэх дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 10 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 12/07, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай” 16/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаагаар эзэмшүүлэх 13 нэгж талбарын газрын хэмжээ, байршил, зориулалт, анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулах бөгөөд дуудлага худалдааг 2024 оны 07 дугаар сарын 26-нд зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

3.Дуудлага худалдаа явуулах тухай зар мэдээг 2024 оны 06 дугаар сарын 21-ны өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж холбогдох журмын дагуу оролцогчдын материалыг газрын биржийн цахим системээр хүлээн авч товлосон хугацаанд дуудлага худалдааг зохион байгуулахыг Газрын даамал (Ш.Адъяадолгор)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

Сумын Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 07-ны өдрийн
А/106 дугаар захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМАНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Эзэмшүүлэх газрын байршил	Газар эзэмшүүлэх зориулалт	Эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/	Дэнчин-гийн хэмжээ /мян.төг/
	1	2	3	4	5
1	Их-Уул Ягаантолгой 6 дугаар баг Хүндэтгэлийн хаалганы хойно (3891031 дугаартай)	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	0.3	10800,0	1080,0
2	Их-Уул Ягаантолгой 6 дугаар баг Хүндэтгэлийн хаалганы хойно (3891032 дугаартай)	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	0.2	7200,0	720,0
3	Их-Уул Ягаантолгой 6 дугаар баг Хүндэтгэлийн хаалганы хойно (3891033 дугаартай)	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	0.2	7200,0	720,0
4	Ноён 10 дугаар баг Хурд ШТС-ын зүүн урд (3891035 дугаартай)	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	0.3	10800,0	1080,0
5	Ноён 10 дугаар баг Хурд ШТС-ын зүүн урд (3891034 дугаартай)	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	0.2	7200,0	720,0
6	Зүлэгт 12 дугаар баг Их Богд худалдааны төвийн хойно (3795371 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.18	3061,7	306,2

7	НИК-ийн агуулахын залгаа баруун хойно (хуучнаар нефть бааз) (3795374 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.11	1762,9	176,3
8	Түүхий эдийн зах (3795373 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.05	850,0	85,0
9	Түүхий эдийн зах (3795372 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.05	850,0	85,0
10	НИК-ийн агуулахын урд (хуучнаар нефть бааз) (3796286 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.25	4250,0	425,0
11	НИК-ийн агуулахын урд (хуучнаар нефть бааз) (3796285 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.25	4250,0	425,0
12	НИК-ийн агуулахын урд (хуучнаар нефть бааз) (3796287 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.25	4250,0	425,0
13	НИК-ийн агуулахын урд (хуучнаар нефть бааз) (3796288 дугаартай)	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор	0.25	4250,0	425,0

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ГАЗРЫН БА

/Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулал

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ГАЗРЫН БА

/ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборын зорижлалттай газар/